

### ТЕХНИКИЙН ДААЛГАВАР № 34

#### ЭРЧИМ ХҮЧНИЙ ЦЕХИЙН УСАН ХАНГАМЖИЙН САЛБАР ШУГАМУУДАД ТАВИГДАХ ЦЭВЭР УСНЫ ТООЛУУР

1. Усан хангамжийн салбар шугамуудыг тоолууржуулах.
2. Ажлын хэвийн горим – 24 цагаар
3. Усны тоолуур LF622 загварын усны зарцуулалтын хэмжүүрийн захиалгын код LF622FAC231E тоолуурын үзүүлэлт:

№	Нэрс	Хэмжих нэгж	Усны тоолуур. LF622FAC231E
1	Тоолуур суурилуулах шугамын диаметр	мм	Ф80
2	Захиалсан тоо	ш	2
3	Цахилгаан хангамж	В, Гц	220, 50
4	Цагт өнгөрүүлэх усны хэмжээ	м <sup>3</sup> /цаг	60
5	Холболтын төрөл		Фланц
6	Аналоги гаралт нь	мА	0-20, 4-20
7	Орчны температур	°С	-20-аас +60
8	Дохионы төрөл	В	20-30
9	Оролтын эсэргүүцэл	кОм	2,7
10	Эсэргүүцлийн ачаалал	Ом	0-750

Шинээр суурилуулах шингэний зарцуулалтын цахилгаан соронзон тоолуур нь LF622 загварын хэмжүүрийн өгөгдөлтэй дүйцэхүйц дараах нөхцөлүүдийг хангасан хэмжүүр байх шаардлагатай.

- Дижитал оролтын функц: Нэмэлт дохио, тоон оруулга байна.
- Дэлгэцэн дээр хэмжилт болон суурилуулах үед гарсан алдааны төрлийг (Error) дэлгэцэн дээр мэдээллэдэг байх. (шаардлагатай бол нэмэлтээр зарцуулалт байхгүй хэмжүүр алдаатай ажиллаж байгаа (теле) дохиог хяналт удирдлагын систем рүү илгээх чадвартай байх)

- Дэлгэцэн дээр шингэний зарцуулалтын бодит утга, нийлбэр утга, урсгалын хурд, хэт авианы хурд, чадал, урсгалын чиглэл гэх мэт үзүүлэлтүүдийг сонголтоор харах боломжийг хангасан байх.
- Шингэний зарцуулалтын тухайн бодит утга, нийлбэр утгыг дундажаар 30 минутын интервалтай 3 сарын турш санах ойндoo хадгалах чадвартай байх. (хугацааны интервалийг сонгож өөрчлөх боломжтой байх)
- Санах ойн программчилсан мэдээ, мэдээллийг хадгалахад зориулагдсан баттареитэй байх.
- Хэмжүүр нь ус, чийг, доргионоос хамгаалсан хатуу хамгаалалтын саванд суурилсан байх шаардлагатай ба түгжээтэй байна.
- IP:67
- Хэмжүүр нь Монгол улсын стандартчлал хэмжил зүйн загварын туршилтанд орж ашиглахыг зөвшөөрсөн жагсаалтанд орсон хэмжүүр байх.

4. Холбогдох бичиг баримтууд

- Паспорт..\Диск\.....1 хувь
- Ашиглалтын заавар нь англи, монгол хэлээр байна.